



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар

А/09

Улаанбаатар хот

Байгууллагын ёс зүйн хороог
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоол, газрын зөвлөлийн хурлын 2018 оны 01 сарын 25-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн журмыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын нийт албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байгууллагын ёс зүйн байнгын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Үүнд:

ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА:

ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

ГИШҮҮД:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА

БАЙР АШИГЛАЛТЫН
АЛБАНЫ ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн явцын тухай мэдээг тухай бүрт гаргаж, газрын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж ажиллахыг Ёс зүйн хорооны даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2017 оны А/14 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ



1150500017